

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

1.1. Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, энэ талаар харьяалах байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх;

Төрийн албаны тухай хууль, төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдан гарсан дүрэм, журмыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд Төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ашиг сонирхлын зөрчилгүй, хүргэх зорилгоор иргэнд шууд үйлчилгээ үзүүлдэг /Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Авто тээврийн төв, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв, Архивын тасаг, Нийгмийн даатгалын хэлтэс/ 8 байгууллагын 111 албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлдэг төхөөрөмж, дуу, дүрсний хяналтын системийг орон нутгийн төсвөөс 58,5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулан 2021 оны 4 дүгээр сараас эхлэн нэвтрүүлээд байна. Мөн 18 сум, 1 тосгонд “Нэг цэгийн үйлчилгээний төв” байгуулах ажлыг эрчимжүүлж, тус төвд үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдад дуу, дүрсний хяналтын систем нэвтрүүлэх ажил 50 хувьтай явагдаж байна. Тус ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2021 оны А/168 дугаар захирамжаар “Төрийн албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг төхөөрөмж ашиглан үнэлэх журам” батлагдсан.



ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

№	Байгууллагын нэр	Нийт үнэлгээний тоо	Маш сайн	сайн	дунд	муу
1	ГХБХБГ	43	38	5	0	0
2	Нийгмийн даатгалын хэлтэс	269	200	67	2	0
3	Архивын тасаг	58	38	18	2	0
4	Улсын бүртгэл	176	158	15	1	2
5	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар	203	171	32	0	0
6	Татварын хэлтэс	235	181	52	2	0
7	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв	1710	1579	118	10	3
	95 хувь	2694	2365	307	17	5

Иргэн та төрийн байгууллагын үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг 70563111 утсанд хандаж өгнө үү.

Мөн байгууллагын үйл ажиллагааны чанар, бүтээмжийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй, чанартай хүргэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын үйлчилгээний жишиг стандартыг боловсруулан аймгийн Засаг даргын 2021 оны А/11 дүгээр захирамжаар батлуулсан. Тус жишиг стандартын дагуу аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 154 төрийн байгууллага өөрийн байгууллагын онцлогт тохируулан байгууллагын үйлчилгээний стандартыг боловсруулж, аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсээр баталгаажуулан, үйл

ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус стандартыг зөрчсөн албан хаагчдад хариуцлага тооцох зорилгоор “Хяналтын хуудас хэрэглэх журам” батлуулсан.

Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн талаар сумдын Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга нарын 2 удаагийн сургалтад мэдээлэл өгч, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 9/957 тоот албан бичгээр төрийн албан хаагчдын хууль бус халаа сэлгээг, таслан зогсоох чиглэлээр үүрэг даалгавар өгч ажиллаа.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд ТАЗСЗ-ийн сургалт, төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах боломжтой иж бүрэн 6 компьютертэй өрөөг тохижуулж, тусгай шалгалтыг зохион байгуулж байгаагаас гадна ТАЗ-өөс зохион байгуулсан сургалтад гишүүдийг хамруулж байна.



1.2. Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан заавар, аргачлалын хүрээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгөх;

Засгийн газрын “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого” 2016 оны 350 дугаар тогтоол, Засгийн газрын “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал батлах тухай” 2018 оны 22 дугаар тогтоолын хүрээнд чиг үүргийн шинжилгээ хийж ажилласан.

Чиг үүргийн шинжилгээг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын албан хаагч тус бүрээр давхардал хийдэл байгаа эсэхийг нягталж албан хаагчдын ачааллыг тэнцвэржүүлэн албан тушаалын гүйцэтгэх чиг үүргүүдийг шинэчлэн аймгийн Засаг даргын 2021 оны “Байгууллагын бүтэц орон тооны хязгаарыг батлах тухай” А/63 дугаар захирамжаар тус газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан.

1.3. Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг зохион байгуулах, энэ талаар үүрэг даалгавар, арга зүйн зөвлөгөө өгөх;

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газраас 2021 оны 3 дугаар сарын 15-17-ны хооронд аймгийн Засаг даргын орлогчоор батлуулсан удирдамжийн дагуу аймгийн төвийн 47 байгууллагад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан бөгөөд уг шалгалтаар байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, төлөвлөгөө, тайланг тусгайлан шалгасан. Үүнээс 12 байгууллага ёс зүйн дүрмийг танилцуулсан баталгааны хуудсыг албан хаагчдын хувийн хэрэгт хавсаргаагүй, 10 байгууллагын ёс зүй зөвлөлийн төлөвлөгөө, тайлан хангалтгүй байсан тул ажлын хэсгийн дүгнэлтээр тус байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.

2021 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 4 байгууллагын ёс зүйн зөвлөлд /АДБ-ийн Хан Хэнтий чуулга, Мал эмнэлгийн газар, Дадал сумын ЗДТГазар, Уламжлалт анагаах ухааны эмнэлэг/ 4 өргөдөл ирснийг утгаар нь авч үзвэл төрийн албан хаагч архидан согтуурсантай холбоотой 2, удирдлагатайгаа зохисгүй харилцсан 2 өргөдөл ирсэн байна. Үүний дагуу байгууллагын ёс зүйн зөвлөл хуралдаж 2 албан хаагчид сануулах, 10 албан хаагчид уучлалт гуйх хариуцлага хүлээлгэсэн. Үүний 2 нь төрийн захиргааны албан хаагч, 10 нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.

Мөн төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, албан үүргээ гүйцэтгэхдээ ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх чиглэлээр 28 байгууллага 32 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 813 албан хаагчдыг хамруулсан байна.

1.4. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд тайлан, мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлэх;

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны жилийн эцсийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 тоот албан бичгээр, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчлийн эхний хагас жилийн тайлан, мэдээг 2021.06.11-ний 51 тоот бичгээр тус тус хүргүүлсэн.

Мөн төрийн албаны шалгалтын тогтолцоог сайжруулах бодлогын судалгаанд зориулсан тоон болон чанарын мэдээ, төрийн албан хаагчидтай холбоотой судалгаа, мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлэн ажилласан.

1.5. Салбар зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах, шийдвэрийн биелэлтийг хангуулах;

Эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл 5 удаа хуралдаж, 20 асуудал хэлэлцэн 22 тогтоол гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. /ирсэн бичиг 63, явсан бичиг 51/

Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдлыг 1 дүгээр хавсралтаар үзүүлэв.

**ХОЁР. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН УЛСЫН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ
ХҮРЭЭНД**

2.1. Харьяалах байгууллагын “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим систем”-д тухай бүр мэдээлэл оруулах;

Хүний нөөцийн нэгдсэн системд Хэнтий аймгийн 184 байгууллагын мэдээллийг оруулах ажлыг шуурхай, хугацаанд нь зохион байгуулсан. Мөн мэдээллийн баяжилтыг 1 дүгээр улиралд багтаан хийхийг 2021 оны 42 дугаар тоот албан бичгээр байгууллага, агентлагийн дарга нарт чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан.

2.2. Төрийн байгууллагыг төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөхөд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

Хүний нөөцийн системд бүртгэл хөтлөхөд гарч буй саад, бэрхшээлийн талаар тухай бүр нь арга хэмжээг авч, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

ГУРАВ. ТӨРИЙН АЛБАНЫ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ХҮРЭЭНД

3.1. Харьяалах байгууллагын хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-д заасны дагуу хийх;

Төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөцийн бүртгэл, төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэний нөөцийн бүртгэл, төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн болон иргэний нөөцийн бүртгэлийг “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу хийж гүйцэтгэн Төрийн албаны зөвлөлд тухай бүрт нь хүргүүлж ажилласан.

Төрийн жинхэнэ албанд ажиллаж байгаад хуульд зааснаар төрийн албаны нөөцөд бүртгүүлэхээр 2 иргэн хүсэлтээ ирүүлснийг бүртгэж авсан.

3.2. Төрийн байгууллага, албан хаагч, иргэдийг нөөцийн санд хамаарах мэдээллээр хангах, энэ талаар бүртгэл хөтлөх;

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сангаас мэдээлэл авахыг хүссэн 2 байгууллагад нөөцийн санд хамаарах мэдээллээр ханган, бүртгэл хөтлөн ажилласан.

Төрийн жинхэнэ албаны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн 2 иргэнд нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн болохыг тодорхойлох баримт бичгийг олгосон.

ДӨРӨВ. МАРГААН ХЯНАН ШАЛГАХ ХҮРЭЭНД

4.1. Маргаан хянан шалгах комиссын үүрэг даалгаврын дагуу асуудлыг шалгах, холбогдох баримт, материалыг бүрдүүлэх, холбогдох этгээдээс тайлбар, тодорхойлолт авах;

2021 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн ТАЗСЗ-д 6 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс 2 өргөдлийг Төрийн албаны зөвлөлд, 1 өргөдлийг гэмт хэргийн шинжтэй байх тул аймгийн Цагдаагийн газарт тус тус шилжүүлсэн. 3 өргөдлийг судалж, шийдвэрлэн иргэнд хариу хүргүүлж ажилласан.

4.2. Зөвлөлийн шийдвэрээр маргаан хянан шалгах комиссын бүрэлдэхүүнд ажиллуулах;

Маргаантай асуудал гараагүй тул хянан шалгах комисс байгуулаагүй.

4.3. Төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах санал Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх, энэ талаар зохих арга хэмжээ авах;

Төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлага гараагүй.

ТАВ. ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХҮРЭЭНД

5.1. “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу шалгалт зохион байгуулах;

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2021.03.12, 13-ны өдрүүдэд “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу зохион байгуулсан. Төрийн албаны ерөнхий шалгалтад 259 иргэн бүртгүүлж, 222 иргэн шалгалтад орсноос ерөнхий мэдлэгийн шалгалтад 56, Монгол хэл, бичгийн шалгалтад 45, дүн шинжилгээ хий чадварын шалгалтад 38 иргэн тус тус тэнцсэн.

Төрийн албаны тусгай шалгалтыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд удирдах албан тушаалд 5, гүйцэтгэх албан тушаалд 9, нийт 14 иргэн ороцож, 14 иргэн тэнцсэн. 13 иргэн ажлын байранд нэр дэвшүүлсэн.

Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг 1 удаа зохион байгуулж албан тушаалд 4 иргэн оролцож, 2 иргэн тэнцсэн.



5.2. Сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах;

Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 144 сул орон тоо байгаагаас төрийн захиргааны удирдах 4, гүйцэтгэх 58, туслах 70, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 12 сул орон тоо байна. Үүнээс 23 сул орон тооны захиалгыг 2021 оны 03, 07 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн сайтад 2021 оны 1, 2 дугаар сард нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.

4. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот, байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий архитектор

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАЛГААР /2021.01.26/

1. Баянхонгор аймаг дахь шүүхийн тамгын газрын Шүүхийн үйлчилгээний хэлтсийн дарга

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАХИАЛГААР /2021.01.25/

1. Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
2. Баян-Агарт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
3. Биндэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
4. Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга

БААН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАХИАЛГААР /2021.01.25/

1. Баан-Өлгий аймгийн Бугат сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч;
2. Баан-Өлгий аймгийн Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч;
3. Баан-Өлгий аймгийн Сатсай сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч;
4. Баан-Өлгий аймгийн Өлгий сумын 19 дугаар цэцэрлэгийн эрхлэгч;
5. Баан-Өлгий аймгийн Өлгий сумын 20 дугаар цэцэрлэгийн эрхлэгч.

ТӨВ АЙМГИЙН ЗАХИАЛГААР /2021.01.25/

1. Баяндэлгэр, Баянцагаан, Баянчандмань, Бүрэн, Заамар, Лүн сумдын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаал /6/
2. Заамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
3. Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн албаны дарга

16. Орон аймаг дахь сүл дүрдэн шүүхийн тамгын газрын Тодорхойлал хэлтэсний дарга

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАХИАЛГААР /2021.01.25/

1. Нэгжлийн хамт олон газрын Байгаль орчин, газар, төсвийн, эрх зүйн хамт олон үйлчилгээний дарга
2. Нэгжлийн хамт олон газрын Ажлын албаны хамт олон үйлчилгээний дарга
3. Нэгжлийн хамт олон газрын Нийслэлийн хамт олон үйлчилгээний дарга
4. Нэгжлийн хамт олон газрын Эрүүл мэнд, халдвар хамт олон үйлчилгээний дарга
5. Нэгжлийн хамт олон газрын Хүнсний эрүүл мэнд, халдвар хамт олон үйлчилгээний дарга
6. Нэгжлийн хамт олон газрын Хөдөлмөрийн эрүүл мэнд, халдвар хамт олон үйлчилгээний дарга
7. Нэгжлийн хамт олон газрын Төсвийн, эрх зүйн хамт олон үйлчилгээний дарга
8. Нэгжлийн хамт олон газрын Өрх хамт олон үйлчилгээний дарга
9. Нэгжлийн хамт олон газрын Хүнсний эрүүл мэнд, халдвар хамт олон үйлчилгээний дарга
10. Нийслэлийн даатгалын хамт олон Бүтээгдэхүүн, Баян-Агарт, Баянхонгор, Нийслэлийн даатгалын хамт олон /3/
11. Төсвийн хамт олон Баян-Овоо сумын төсвийн үйлчилгээний дарга
12. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Төсвийн, эрх зүйн хамт олон үйлчилгээний дарга
13. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Баян-Агарт, Баян-Овоо, Дархан, сумдын Гурванбүтээгдэхүүн хамт олон /4/
14. Хөдөлмөр, халдварын үйлчилгээний газрын Хүнс төсвийн даатгал тусламж хамт олон үйлчилгээний дарга
15. Хөдөлмөр, халдварын үйлчилгээний газрын Нийслэлийн сумын, Гурванбүтээгдэхүүн хамт олон /4/
16. Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хамт олон үйлчилгээний, үйлдвэр, дотоод аудит хамт олон үйлчилгээний дарга
17. Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэл, технологийн, нийслэлийн хамт олон үйлчилгээний дарга
18. Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Төсвийн, эрх зүйн хамт олон үйлчилгээний дарга
19. Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Төсвийн, эрх зүйн хамт олон үйлчилгээний дарга
20. Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн хамт олон үйлчилгээний дарга
21. Хөдөлмөр, халдварын үйлчилгээний газрын Хүнс төсвийн даатгал тусламж хамт олон үйлчилгээний дарга
22. Хөдөлмөр, халдварын үйлчилгээний газрын Нийслэлийн сумын, Гурванбүтээгдэхүүн хамт олон /4/

5.3. Шалгалтын- комисс байгуулах;

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2021 оны 02, 14 дүгээр тогтоолоор төрийн албаны тусгай шалгалтын комисс, 15 дугаар тогтоолоор ерөнхий шалгалт зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнийг тус тус байгуулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 141 дүгээр тогтоол, түүнийг хэрэгжүүлэх аргачлалын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан бөгөөд хорио цээрийн дэглэмийн хүрээнд Улсын онцгой комиссын шийдвэр, Эрүүл мэндийн яамны зөвлөмжийг мөрдөж ариутгал халдваргүйтгэл, шалгалтад оролцогчдын халууныг зайнаас хэмжих, дэглэмийг мөрдүүлэх зэрэг үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж ажиллав.



Албан тушаалын сул орон тоонд зохих журмын дагуу нэр дэвшүүлэх;

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн дагуу Төрийн албаны тусгай шалгалт өгч хамгийн өндөр оноо авсан иргэдийг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлэх салбар зөвлөлийн 13 тогтоолыг гаргасан.

5.4. Нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

Төрийн албаны тусгай шалгалт өгч хамгийн өндөр оноо авсан 13 иргэнийг сул орон тоонд нэр дэвшүүлсэн бөгөөд нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилт 100 хувьтай байна.

ЗУРГАА. ХЯНАЛТ ТАВИХ, АУДИТ ХИЙХ ХҮРЭЭНД

- 6.1. Харьяалах төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудитыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан аргачлал, удирдамжийн дагуу хийх;
Аргачлал, удирдамж ирээгүй.
- 6.2. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд Төрийн албаны зөвлөлөөс баталсан аргачлал, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
Аргачлал, удирдамж ирээгүй.
- 6.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих;

Аймгийн хэмжээнд орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал салбарууд болох дэд бүтэц, аялал жуулчлал, эрүүл, мэнд боловсролын салбарт 1264 нарийн мэргэжилтэй боловсон хүчний дутагдал байгаа судалгаа гарсан. Тиймээс дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, төрийн албан хаагчдыг давтан сургах, чадавхижуулах, мэргэшүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт “Зөгийн үүр” арга хэмжээг баталсан. Үүний хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 215 компани, ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, баяжуулах, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллаж, орон нутагт шаардлагатай мэргэжилтэй ажилтан, боловсон хүчний хангалтыг сайжруулахад санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлээд байна. Тус хөтөлбөрийн нээлтийг 2021.06.18-ны өдөр цахимаар иргэдэд танилцуулсан.



Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрөө 4 жилээр шинэчлэн баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч 23 агентлагийн дарга, 18 сум, 5 тосгоны Засаг дарга нар нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрөө 3 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж байна.

Ковид 19 цар тахлын үед аймгийн Онцгой комиссын хуралдаанд 22 удаа асуудал оруулж, төрийн албан хаагчдыг эрсдлээс хамгаалах зорилгоор ажлын цагийг богиносгох, зайнаас ажиллах шийдвэрүүдийг гаргуулж, 25 албан хаагчдыг сувилалд амруулах асуудлыг шийдвэрлүүлсэн.

Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрөө шинэчлэн батлуулж, албан хаагчдын ажилласан жил, ажлын амжилтыг харгалзан үзэж жил бүр 3 хүртэлх албан хаагчдыг орон сууцтай болоход нь 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр тусгасан.

ДОЛОО. СУРГАЛТ СУДАЛГАА, СУРТАЛЧИЛГАА ХИЙХ ХҮРЭЭНД


7.1. Төрийн албаны зөвлөлөөс баталсан хөтөлбөр, удирдамжийн дагуу сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

Удирдлагын академиас явуулсан мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 4 албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 9 албан хаагч тус тус хамрагдаж сертификатаа авсан.

Ковид 19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан танхимын сургалтууд хойшлогдоод байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар ЗГХЭГ, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Өөрчлөлтөд дасан зохицож удирдах нь”, “E-mongolia цахим үйлчилгээний систем”, “Цахим орчинд ажиллахад үүсэх эрүүл мэндийн асуудал”, “Сургалт, үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ” зэрэг 8 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 658 албан албан хаагч хамрагдсан.

7.2. Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, үзэл баримтлалыг төрийн албан хаагч болон олон нийтэд танилцуулах, сурталчлах;

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шийдвэр, төрийн албаны мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалттай холбоотой бусад мэдээ мэдээллийн талаар мэдээллийн самбарт болон www.khentii.mn цахим хуудсанд байршуулан сурталчлах ажлыг тогтмолжуулаад байна.



Мөн цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр нь Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар пэйж хуудсаар болон хандалт ихтэй сошиал зарын бүлгэмүүдэд дамжуулан мэдээлэн ажиллаж байна.



7.3. Төрийн алба, төрийн албан хаагчийн талаар судалгаа хийх;

Эрхэлсэн түшмэлээс тэргүүн түшмэл, ахлах түшмэлээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд шатлан дэвших боломжтой эмэгтэй албан хаагчдын судалгаа, 2020 оны аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийн үр дүнд иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчөөр сонгогдсон, одоогийн Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын судалгаа, мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах боломжтой албан хаагчдын судалгаа, шинээр томилогдсон албан хаагчдын судалгааг тус, тус гаргасан.

7.4. Орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг боловсруулах, хянаж батлахад санал гаргах;

2021 оны орон нутгийн төсөвт Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 15.0 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын төсвийн багцад суулгуулсан.

НАЙМ. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

8.1. Төрийн алба, төрийн албан хаагчийн талаарх мэдээ мэдээлэл, материал, судалгааг харьяалах байгууллагаас гаргуулж авах;

2020 оны жилийн эцсийн төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардлын нэгдсэн судалгаа, Төрийн байгууллагын албан хаагчдын 2020 онд сургалтад хамрагдсан тухай судалгааны нэгтгэл, Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх талаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл, төрийн албан хаагчдын тоо бүртгэлийн тайлан, ёс зүйн зөрчлийн талаарх тоон мэдээ, 2020 оны аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийн үр дүнд ИХТ-өөр сонгогдсон, одоогийн Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын судалгаа, мэргэшүүлэх багц сургалтын судалгаа, шинээр томилогдсон албан хаагчдын судалгаа, төрийн албаны шалгалтын тогтолцоогоор бодлогын судалгаа хийхэд шаардагдах тоон судалгааг холбогдох байгууллагаас гаргуулж, нэгтгэн Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академид цаг хугацаанд нь хүргүүлж ажиллав.

8.2. Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах;

Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр олгох, ахиулан олгох санлыг аймгийн Засаг даргад өргөн мэдүүлж, аймгийн Засаг даргын 2021 оны Б/7, Б/11 дүгээр захирамжаар нийт 74 албан хаагчид зэрэг дэв олгосон шийдвэрийг гаргуулсан.

8.3. Төрийн албан хаагчийг холбогдох журамд заасны дагуу шагнаж урамшуулах санал гаргах;

“Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдэг”-ээр шагнуулахаар төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа 3 төрийн албан хаагчийн материалыг ТАЗСЗ-ийн 2021 оны 08 дугаар албан тоотоор ТАЗ-д хүргүүлсэн.

8.4. Төрийн албаны зөвлөлөөс албан тушаалын тодорхойлолт хянах чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх;

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Хүний хөгжил, Эдийн засаг, Сум, тосгодын хөгжил гэсэн бүлгүүдэд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр 255 зорилт дэвшүүлэн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан АЗДТГ-ыг чиг үүрэгт өөрчлөлт орж сум, орон нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хэрэгцээ шаардлага гарч байгаа тул Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагын мэргэжилд инженер, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагын мэргэжилд эдийн засаг гэж тус тус нэмж оруулах, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын сумын газрын даамлын сул орон тоо тус аймагт нөхөгдөхгүй байгаатай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодез зураг зүйн газарт газрын даамлын албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагын мэргэжилд инженер гэж нэмж оруулахаар хүсэлтийг 2021 оны 48 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

**ЕС. ЗӨВЛӨЛӨӨС ҮҮРЭГ ЧИГЛЭЛ БОЛГОСОН БУСАД АРГА ХЭМЖЭЭГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ**

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Өндөр насны тэтгэвэртэй холбогдох зарим асуудлын тухай” 07 дугаар зөвлөмж, Хууль хэрэгжүүлэх тухай 2021 оны “Мэдэгдэл”, “Төрийн албаны шалгалт өгөх болзол журам”-д заасны дагуу гарсан тогтоол, төрийн албаны ерөнхий шалгалт зохион байгуулах тухай, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулах талаар тус тус ирүүлсэн үүрэг чиглэлийг агентлаг байгууллагын дарга нар, сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт албан бичгээр чиглэл өгч ажилласан.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ж.ГАНБААТАР

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

С.ОЮУН-ЭРДЭНЭ

1 дүгээр хавсралт

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг тооцсон байдал:

	ТАЗСЗ-өөс гарсан тогтоолын			Гарсан шийдвэрийн товч	Тогтоолын хэрэгжилт
	Утга	Огноо	№		
1	Шагналд тодорхойлох тухай	2021.01.13	01	Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Ч.Эрдэнэбаатар, Дадал сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга С.Уянга, Бэрх тосгоны захирагчийн ажлын албаны жижүүр, үйлчлэгч Д.Ариунаа нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар уламжлах.	2021.01.13-ны өдрийн 08 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд уламжилсан.
2	Шалгалтын комисс байгуулах тухай	2021.02.04	02	Төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах шалгалтын комисст байгуулах.	2021.02.01-ний өдөр тусгай шалгалт зохион байгуулсан.
3	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.02.04	03	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /118/ авсан Баатарцогтын Дарханбаатарыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх.	Аймгийн ЗДТГ-ын даргын 2021.03.01-ны өдрийн Б/19 дугаар тушаалаар Б.Дарханбаатарыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргаар томилсон.
4	Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.02.04	04	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /111/ авсан Ганзоригийн Өнөболдыг Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын	Биндэр сумын Засаг даргын 2021.03.15-ны өдрийн Б/09 дугаар тушаалаар Г.Өнөболдыг Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын даргаар томилсон.

				даргын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх.	
5	Баян-Адарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.02.04	05	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /93/ авсан Гантөмөрийн Чулуунсайханыг Баян-Адарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын сул орон тоонд томилуулах.	Баян-Адарга сумын ИТХ-ын 2021.03.11-ний өдрийн 08 дугаар тогтоолоор Г.Чулуунсайханыг Баян-Адарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргаар томилсон.
6	Биндэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.02.04	06	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /106/ авсан Бумбаагийн Нямдэлгэрийг Биндэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын сул орон тоонд томилуулах.	Биндэр сумын ИТХ-ын 2021.03.11-ний өдрийн 20 дугаар тогтоолоор Б.Нямдэлгэрийг Биндэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргаар томилсон.
7	Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.02.04	07	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /45/ авсан Баатарын Даваахүүг Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчийн сул орон тоонд томилуулах.	Мэргэжлийн хяналтын газрын даргын 2021.02.16-ны өдрийн Б/07 дугаар тушаалаар Б.Даваахүүг Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчаар томилсон.
8	Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн сул орон	2021.02.04	08	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /91/ авсан Ганхуягийн Бүжмааг Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын	Мэргэжлийн хяналтын газрын даргын 2021.02.16-ны өдрийн Б/09 дугаар тушаалаар Г.Бүжмааг Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар

	тоонд нэр дэвшүүлэх тухай			байцаагчийн сул орон тоонд томилуулах.	хамгааллын хяналтын улсын байцаагчаар томилсон.
9	Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний эрүүл ахуйн асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.02.04	09	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /70/ авсан Болдбаатарын Саранчимэгийг Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний эрүүл ахуйн асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн сул орон тоонд томилуулах.	Мэргэжлийн хяналтын газрын даргын 2021.02.16-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар Б.Саранчимэгийг Мэргэжлийн хяналтын газрын Хүнсний эрүүл ахуйн асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчаар томилсон.
10	Татварын хэлтсийн Баян-Овоо сумын татварын улсын байцаагчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.02.04	10	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /90/ авсан Батаагийн Ундрахцэцэгийг Татварын хэлтсийн Баян-Овоо сумын татварын улсын байцаагчийн сул орон тоонд томилуулах.	Татварын хэлтсийн даргын 2021.03.17-ны өдрийн Б/186 дугаар тушаалаар Б.Ундрахцэцэгийг Баян-Овоо сумын татварын улсын байцаагчаар томилсон.
11	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэл, технологи, нийтийн хоолны асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.02.04	11	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /72/ авсан Хаш-Эрдэнийн Нандин-Эрдэнийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэл, технологи, нийтийн хоолны асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулах.	Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2021.02.01-ний өдрийн Б/12 дугаар тушаалаар Х.Нандин-Эрдэнийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэл, технологи, нийтийн хоолны асуудал хариуцсан мэргэжилтнээр томилогдсон.
12	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар	2021.02.04	12	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /20/ авсан Жамбалсүрэнгийн Алтантөгсийг	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021.02.18-ны өдрийн Б/10 дугаар тушаалаар

	тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай			Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулах.	Ж.Алтантөгсийг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилсон.
13	Санал уламжлах тухай	2021.02.04	13	Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн төрийн захиргааны албан хаагчдын төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, 2020 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан үзэж ахлах түшмэлийн ангиллын 6, дэс түшмэлийн ангиллын 34, туслах түшмэлийн ангиллын 20 албан хаагчдад зэрэг дэв олгуулах санал уламжлах.	Аймгийн Засаг даргын 2021 оны Б/7 дүгээр захирамжаар нийт 60 албан хаагчид зэрэг дэв олгосон.
14	Шалгалтын комисс байгуулах тухай	2021.02.23	14	2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр бүртгэл хийгдсэн төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах шалгалтын комисс байгуулах.	Төрийн албаны тусгай шалгалтыг Салбар зөвлөлийн гишүүн, Шүүхийн тамгын газрын дарга Б.Баярсайханаар ахлуулсан комисс зохион байгуулсан.
15	Салбар комисс байгуулах тухай	2021.03.04	15	Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах салбар комисс байгуулах.	2021 оны 3 сарын 04-ний төрийн албаны тусгай шалгалтыг 7 хүний бүрэлдэхүүнтэй салбар комисс зохион байгуулсан.

16	Жаргалтхаан сумын Засаг даргын Тамгын газрын даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.03.04	16	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /118/ авсан Сэсээрийн Мөнхдэлгэрийг Жаргалтхаан сумын Засаг даргын Тамгын газрын даргын сул орон тоонд томилуулах.	Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны захирамжаар томилогдсон.
17	Мэргэжлийн хяналтын газрын Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.03.04	17	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /55/ авсан Өлзийбатын Маналжавыг Мэргэжлийн хяналтын газрын Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчийн сул орон тоонд томилуулах.	Мэргэжлийн хяналтын газрын даргын 2021.07.05-ны өдрийн Б/24 дүгээр тушаалаар Ө.Маналжавыг Мэргэжлийн хяналтын газрын Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчаар томилсон.
18	Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	2021.03.04	18	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /36/ авсан Пүрэвдоржийн Эрдэнэчимэгийг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулах.	Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны тушаалаар П.Эрдэнэчимэгийг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилсон.
19	Б.Содбилэгийг төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх тухай	2021.05.11	19	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн Батбаатарын Содбилэг нь зургаан сараас дээш хугацаагаар суралцахаар төрийн албанаас түр	Батбаатарын Содбилэгийг төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэсэн.

				чөлөөлөгдсөн тул төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх.	
20	Б.Пүрэвжаргалыг төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх тухай	2021.05.11	20	Норовлин сумын Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн Байгальмаагийн Пүрэвжаргал өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдаж ажлаас чөлөөлөгдөн хүсэлтээ бичгээр гаргасан тул төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх.	Байгальмаагийн Пүрэвжаргалын төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэсэн.
21	Санал уламжлах тухай	2021.05.11	21	Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цэнхэрмандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төрийн захиргааны албан хаагчдын төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, 2020 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан үзэж ахлах түшмэлийн ангиллын 1, дэс түшмэлийн ангиллын 7, туслах түшмэлийн ангиллын 6 албан хаагчдад зэрэг дэв олгуулах санал уламжлах.	Аймгийн Засаг даргын 2021 оны Б/11 дүгээр захирамжаар нийт 14 албан хаагчид зэрэг дэв олгосон.
22	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Норовлин сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал	2021.05.11	22	Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /72/ авсан Байгальмаагийн Пүрэвжаргалыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Норовлин сумын Хөдөлмөр	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2021.05.22-ны өдрийн Б/22 тушаалаар Б.Пүрэвжаргалыг Норовлин сумын Хөдөлмөр эрхлэлт,

	хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай			эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх.	халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилсон.
--	---	--	--	---	---

